

# **ӨМНӨГОВЬ АЙМАГ, "ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТӨВ" ТӨААТҮГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ**

2025 оны 05 дугаар сарын 12 өдөр      Дугаар:...

Энэхүү Хамтран ажиллах, харилцан ойлголцлын санамж бичиг /цаашид "Санамж бичиг" гэх/-ийг нэг талаас Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбат, /цаашид "Өмнөговь аймаг" гэх/, нөгөө талаас "Төр хувийн хэвшлийн түншлэл төв" ТӨААТҮГ, түүнийг төлөөлж Газрын захирал М.Амгаланбаатар /цаашид "ТХХТТ" гэх/, бид /цаашид тусад нь "Тал", хамтад нь "Талууд" гэх/ хооронд хоёр байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор харилцан тохиролцож энэхүү "Санамж бичиг"-ийг байгуулав.

## **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Өмнөговь аймаг болон ТХХТТ-ийн хамтын ажиллагаа нь холбогдох хууль, дүрэм, журамд нийцсэн бөгөөд санамж бичиг байгуулах болсон үндэслэл, шалтгаан нөхцөлийн талаар талууд бүрэн ойлголцсон болно.

1.2.Талууд хамтын ажиллагаандаа хууль дээдлэх, хоорондын харилцааны зохистой хэм хэмжээг баримтлан харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэн, нээлттэй, ил тод байх, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчмуудыг баримтална.

1.3.Энэхүү санамж бичиг нь талууд цаашдын харилцаандаа дагаж мөрдвөл зохих үндсэн баримт бичиг болох бөгөөд харилцан нөгөө талдаа хууль, эрх зүйн болон санхүүгийн аливаа үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

## **ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ**

2.1.Санамж бичгийн хүрээнд дараах чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:

2.1.1.Талууд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, бизнесийн орчинд тулгарч буй бэрхшээлийг арилгахад төр, хувийн хэвшлийнхэн харилцан ойлголцох, улмаар хамтран ажиллах механизмыг хөгжүүлэх, хувийн хэвшлийн салбарыг бэхжүүлэх чиглэлээр идэвхи санаачилгатай ажиллах;

2.1.2.Талууд бизнесийн хууль, эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор хамтын хүчин чармайлтаар төрийн бодлого, шийдвэр гаргах үйл ажиллагаанд шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж бизнес эрхлэгчдийн саналыг тусгахад дэмжлэг үзүүлэх;

2.1.3.Талууд нь хоёр байгууллагын харилцан хамтын үйл ажиллагааг харилцан дэмжиж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомжийг бизнес эрхлэгч, олон нийтэд хүргэх, таниулах, сурталчлах ажлыг хамтран зохион байгуулах;

2.1.4.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх чиглэлээр төрийн байгууллага, бизнес эрхлэгчдийн төлөөллийг оролцуулсан уулзалт, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулах, уулзалтаас гарсан саналыг холбогдох төрийн байгууллагуудад уламжлах;

2.1.5.Энэхүү санамж бичгийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;

2.1.6.Талууд өөр, өөрсдийн зохион байгуулж буй арга хэмжээ, уулзалт, зөвлөгөөн, сургалтанд нөгөө талын оролцоог хангах, дэмжих арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.2.Талууд санамж бичгийн хүрээнд харилцан тохиролцсоны үндсэн дээр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хариуцах нэгж, ажилтнуудыг томилон ажиллуулах ба хэрэгжилтийг жил тутам дүгнэнэ.

### ГУРАВ. БУСАД

3.1.Энэхүү Санамж бичиг нь талууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд 3 /гурав/ жилийн хугацаанд хүчинтэй байна.

3.2.Талууд Санамж бичигт харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Санамж бичгийн адил хүчин төгөлдөр байна.

3.3.Санамж бичгийн хүрээнд харилцан солилцсон мэдээллийг зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахыг хоригоно.

3.4.Талууд энэхүү Санамж бичгийг хэрэгжүүлэх хүрээнд үүсэж болох аливаа маргааныг үл маргаж журмаар харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

3.5.Энэхүү санамж бичгийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр 2 эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд хууль зүйн адил хүчинтэй байна.

### САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



Н.ЭНХБАТ

"ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН  
ТҮНШЛЭЛИЙН ТӨВ" ТӨААТҮГ-



М.АМГАЛАНБААТАР



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН  
ТҮНШЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ЖАГСААЛТ

1. Даланзадгад суманд дулаан, цахилгаан хосолсон станц байгуулах;
2. Гурвансайхан нисэх онгоцны буудлыг Олон Улсын 4DE зэрэглэлийн онгоцны буудал болгох;
3. Нар, салхины тус бүр 100 мВт хүртэл хүчин чадалтай цахилгаан станц барьж, байгуулах;
4. Говийн бүсэд үйлдвэр, технологийн парк байгуулах;
5. Даланзадгад сумыг Монгол Улсын хэвтээ тэнхлэгийн автозамтай холбох;
6. Даланзадгадаас Сэврэй, Ноён, Гурвантэс сум чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж бүрэн ашиглалтад оруулах;
7. Ханхонгор сумын "Шар тээгийн уулзвар" дээр тээвэрчдийн үйлчилгээний логистик төв байгуулах;
8. Ханбогд, Цогт-Овоо, Гурвантэс сумдад тээвэр, логистикийн төв байгуулах;
9. Олон овоотын бүлэг ордоос Гурвантэс сумын төв хүртэл хатуу хучилттай автозам барих;
10. Даланзадгад, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдад 2000-аас дээш айлын орон сууцны хотхон барьж байгуулах;
11. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа нийгмийн дэд бүтцийн бүтээн байгуулалт;
12. Бүс нутгийн аялал жуулчлал, хил орчмын аялал жуулчлалын дэд бүтцийн байгуулалт хийх.